



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

**НИЙГИЙН АЛБАНД НИЙГИЙН  
БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН  
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ТУХАЙ ХУУЛЬ**

**100 АСУУЛТ, ХАРИУЛТ**

**УЛААНБААТАР ХОТ  
2012 ОН**

DDC  
345.001  
H-615

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН  
БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН  
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ТУХАЙ ХУУЛЬ**

**100 АСУУЛТ, ХАРИУЛТ**

---

Хэвлэлд бэлтгэсэн: О.ЦЭНГЭЛБААТАР  
Т.МӨНХТУНГАЛАГ

Хянан тохиолдуулсан: Д.ДУЛАМСҮРЭН

Хэвлэгдсэн хугацаа: 2012 оны 4 дүгээр сар

© Авлигатай тэмцэх газар, 2012 он

ISBN 978-99962-68-03-8

“М.И.М.” Хэвлэлийн газар

## **1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг батлан гаргах шаардлага юу байсан бэ?**

- Монгол Улсын Их Хурал Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Монгол Улсад засаглалыг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албыг нийтийн алба болгон зохион байгуулах, түүний ил тод, хариуцлагатай, шударга үйл ажиллагааг бэхжүүлэх, нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн сонирхлыг хувийн сонирхлоос дээгүүрт тавих зэрэг шаардлагыг үндэслэн хууль санаачлагчид уг хуулийг боловсруулсан байна. Ашиг сонирхлын зөрчил бол авлигыг үүсгэж болзошгүй нэг шалтгаан нөхцөл юм. Албан тушаалтны санхүүгийн, гэр бүлийн, найз нөхдийн зэрэг аливаа хувийн сонирхол албан үүрэгт нь нөлөөлж хэрхэвч болохгүй. Шийдвэрийг шударга гаргах хэрэгтэй төдийгүй шударга гарч байгаа гэдэгт ч эргэлзээ төрүүлэхгүй байх хэрэгтэй. Учир нь ашиг сонирхлын зөрчил бол аливаа байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд хохирол учруулж, олон нийтийн итгэлийг сулруулдаг. Энэ үүднээс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь **албан тушаалтнуудыг, төрийн албан хаагчдыг албан тушаалын гэмт хэрэг үйлдэхээс, олон нийтийн үндэслэлгүй хардлагаас хамгаалж чадна.** Ашиг сонирхлын зөрчлийг хуульчлан зохицуулснаар авлига болон бусад зүй бус үйлдэл гарах нөхцөл буурна, улс орны эдийн засгийн үр ашиг дээшилнэ, нийгмийн шударга ёсны тогтолцоо бэхжинэ, олон нийтийн итгэл нэмэгдэнэ.

## **2.Энэ хуулиар ямар харилцааг зохицуулсан бэ?**

- Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн шаардлагын үндэслэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, албан тушаалтан хувийн ашиг сонирхлын байдлаа мэдүүлэх болон түүнийг шалгах ажиллагаа, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчигчдөд

хүлээлгэх хариуцлагыг уг хуулиар зохицуулсан болно.

### 3.Ашиг сонирхлын зөрчлийг удирдах ямар механизмыг бүрдүүлсэн бэ?

- Ашиг сонирхлыг зохицуулах нэн тэргүүний зорилго бол нийтийн албаны бодлого тодорхойлох, шийдвэр гаргах үе шатан дахь шударга байдал, бүхэлдээ төрийн удирдлагын шударга байдлыг хамгаалах явдал юм. Ашиг сонирхлын зөрчлийг дараах 4 механизмаар зохицуулдаг байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд ч энэхүү механизмыг бүрдүүлсэн.



Ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдлыг хянах, олж илрүүлэх зорилгоор бүртгэх, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг авах, мөн ашиг сонирхлын зөрчилтэй байдалд орж болзошгүй нийтийн албан тушаалтан уг байдлаас зайлсхийх ёс зүйн үүргийг тодорхойлж, оноох зэрэг арга хэмжээ байдаг. Үүнээс гадна ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх механизмын нэгэн томоохон зохицуулалтын арга бол ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдлыг хориглох явдал юм. Ингэснээр сонирхлын зөрчил илрэн гардаг гол нөхцөлүүдийг тодорхойлон, тухайн нөхцөл байдалд хүргэхгүй байх зорилгоор нийтийн албан тушаалтны тодорхой зан үйл, үйлдлийг хязгаарлаж хориглодог. Энэхүү механизмыг уг хуулийн 2 дугаар бүлгийн 7, 8, 9 дүгээр зүйл, 3 дугаар бүлгийн 10-22 дугаар зүйлд тус бүр тусгасан тодорхой заалтуудаар нарийвчлан зохицуулсан юм. Нийтийн албан тушаалтан нэгэнт ашиг сонирхлын зөрчилд орсон тохиолдолд тэрээр ашиг сонирхлоо зарлах, хувийн сонирхолд нөлөөлөхгүйц шийдвэр гаргахад оролцохоос татгалзах, албан үүргийг нь зөрчил үүсэхгүй чиг үүрэгт шилжүүлэх, албан хаагчийн ажил үүргийг дахин өөрчлөх тодорхойлох, зөрчил үүсгэх чиг үүргээс чөлөөлөх гэх мэт

байдлаар шийдвэрлэнэ. Хуулийн 4 дүгээр бүлгийн 23-26 дугаар зүйл, 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлд ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх арга замуудыг тусгасан байна. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хориглох, хувийн ашиг сонирхлоо мэдүүлэх, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэж зохицуулсан хэм хэмжээг нийтийн албан тушаалтан зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох механизм ажилласнаар ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт хэрэгжих бодит нөхцөлөөр бүрэн хангагддаг байна. Тиймээс хариуцлагын төрлүүдэд сануулах, цалинг тодорхой хэмжээгээр бууруулах, торгууль ногдуулах, хууль бус үйл ажиллагааг нь хүчингүй болгох, албан тушаалаас бууруулах, нийтийн албанаас халах зэргийг оруулж хуульчилсан байна. Хуулийн 5 дугаар бүлгийн 29 дүгээр зүйлд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нэгбүрчлэн тусгасан билээ.

#### **4.Нийтийн албан тушаалтан гэдэгт хэнийг хамааруулах вэ?**

- Авлига, албан тушаалын гэмт хэрэг болон ашиг сонирхлын зөрчлийг зөвхөн төрийн албатай хамааралтай мэт явцуу ойлголтыг өөрчлөх зорилгоор хууль тогтоогчид энэхүү нэр томъёог авч хэрэглэсэн. Нийтийн албан тушаалтан гэдэгт төрийн алба болон татвар төлөгчдийн бий болгосон төсвийн хөрөнгөтэй их бага ямар нэгэн хэмжээгээр харилцдаг субъектийг хамааруулан ойлговол зохино. Судлаачдын үзэж байгаагаар төрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтнууд, төрийн өмчит компанийн удирдлагууд, ямар нэгэн байдлаар нийтийн эрх ашгийг илэрхийлж байгаа буюу үр ашгийг нь нийтээрээ хүртэх гадаадын техникийн туслалцаатай хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд ажиллаж буй удирдах албан тушаалтнуудыг нийтийн албанд оруулдаг байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд нийтийн албан тушаалтан буюу хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг заасан байна. Нийтийн албан тушаалтанд төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн

удирдах албан тушаалтан, хууль тогтоомжийн дагуу, эсхүл улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд хамаарна.

#### **5.Дээр дурдсан этгээдээс бусад этгээд уг хуулийн үйлчлэлд хамаарах уу?**

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасны дагуу хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтад орсон бүх албан тушаалтан уг хуулийн үйлчлэлд буюу нийтийн албан тушаалтанд нэгэн адил хамаарна. Уг жагсаалтыг Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батлахаар хуульд заасан байна.

**6.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээдээс бусад этгээд болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос баталсан албан тушаалын жагсаалтад ороогүй төрийн албан хаагчийн хувьд ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?**

- Бусад төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон асуудлыг энэ хуулийг баримтлан шийдвэрлэж болно.

#### **7.Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?**

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд “ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал хэмээн тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн хувьд нэг талаас олон нийтийн эрх ашигт үйлчлэх үүрэг, нөгөө талаас хувийн сонирхол хоорондоо зөрчилдөхийг ашиг сонирхлын зөрчил

хэмээн ойлгож болно. Нийтийн албан тушаалтны хувийн сонирхол албан үүргийг нь давамгайлах буюу нийтийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тохиолдолд төр, байгууллагын ашиг сонирхол орхигдох буюу зөрчигдөх нөхцөл байдал үүсдэг байна.

## **8.Нийтийн ашиг сонирхол гэж юуг хэлж байна вэ?**

- Хуульд “нийтийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэл хэмээн тодорхойлсон. Албан тушаалтан Таны хашиж байгаа ажил, алба бол зөвхөн нийтийн ашиг сонирхолд чиглэж байх ёстой. “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”-ийн 87 дахь талд “Нийтийн ашиг сонирхол /public interests/ гэдэг нь хувь хүмүүсийн тус тусын сонирхлын нийлбэр, эсхүл тухайн нэг бүлгийн сонирхол биш, харин нийт иргэдийн нийтлэг сонирхол юм. Төрийн бүх албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг өөрсдийн болон хувийн ашиг сонирхлоос ангид байлгах үүрэгтэй байдаг. Энэ зарчим Засгийн газрын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа, үйлчилгээ үзүүлж байгаа хэн боловч тэдний төрийн жинхэнэ албан хаагч, орон тооны болон орон тооны бус, түр, гэрээт ажилтан, удирдах зөвлөлийн гишүүн, зөвлөх, сайн дурын ажилтан байхаас үл хамааран бүгдэд хамааралтай” хэмээн бичсэн байна.

## **9.Хувийн ашиг сонирхол гэдэгт юуг хамааруулан ойлгож болох вэ?**

- “Хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ. “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”-ийн 81 дэх талд “Хувийн ашиг сонирхол /private interests/ гэдэгт ажилтанд байж болох хувийн, мэргэжлийн, бизнесийн сонирхлоос гадна түүний хувийн болон ажил төрлийн холбоотой хүмүүсийн сонирхлыг ойлгодог. Энд хамаатан садан, танил талыг нь хамруулж болно. Өөрөөр хэлбэл, хувийн ашиг сонирхол гэдэг нь тухайн ажилтанд ашиг хонжоо бий болгох, эсхүл хор хөнөөл учруулж болох хүмүүсийн, эсхүл бусдад ашиг хонжоотой, эсхүл давуутай бус байдал бий болгохыг

зорьж байгаа тухайн ажилтны сонирхол юм. Ийм сонирхолд санхүүгийн бодит, эсхүл болзошгүй ашиг, алдагдал, өмч хөрөнгө, хувьцаа, төлөгдөөгүй зээл, эсхүл бэлэг сэлт, хангамж, үүний дотор ажил олгох, давхар ажил гүйцэтгэх явдал багтаж болно. Хувийн бусад сонирхол заавал хөрөнгө мөнгөтэй холбоотой бус боловч тухайн ажилтны санаа бодол, шийдвэрийг өөрчилж болох хувийн болон гэр бүлийн харилцаа, спорт, соёлын үйл ажиллагаа мөн адил хамаарч болно” гэжээ.

#### **10. “Хамаарал бүхий этгээд” гэж хэнийг хэлэх вэ?**

- Та нийтийн алба хашиж байгаа бол таны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, мөн гэр бүлийн гишүүн, таны эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү тантай “хамаарал бүхий этгээд” юм. Үүнд тантай хамтран амьдрагч болон бусад нэгдмэл сонирхолтой этгээд ч мөн таны хувьд хамаарал бүхий этгээд болно. Хуулийн 3 дугаар бүлэгт албан тушаалтан Таны хамаарал бүхий этгээдийнхээ хувийн ашиг сонирхолд нийцүүлэн үүсгэж болзошгүй харилцааг 12 төрлийн хориглолт, хязгаарлалт тус бүрээр зохицуулсан.

#### **11. Тэгвэл нэгдмэл сонирхолтой этгээд гэдэгт ах дүү, төрөл саднаа ойлгож болох уу?**

- Болохгүй. Тантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг нэгдмэл сонирхолтой этгээдэд хамааруулан ойлгоно. Тэгэхээр Та төрсөн ахтайгаа ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой байсан ч ах тань таны хувьд “хамаарал бүхий этгээд” юм.

#### **12. Ашгийн төлөө үйл ажиллагаа гэх ойлголтыг хуульд чухам хэрхэн заасан байдаг вэ?**

- Компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг “ашгийн төлөө үйл ажиллагаа” гэж хуульд тайлбарласан.

#### **13. Хандив ба бэлэгний талаар тайлбарлана уу?**

- Хандив нь “нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн



эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэх” явдал юм. Харин бэлэг гэдэгт “нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг” ойлгоно. Тэгэхээр бэлэг гэдэг нь нийтийн албан тушаалтанд өөрт нь өгч байгаа эд хөрөнгө, үйлчилгээ гэх мэт ямар нэгэн санхүүгийн үр ашиг юм байна. Хандивыг тодорхой зориулалтаар өгч байгаа гэдгээрээ ялгаатай. Үнэ төлбөргүй өгөх, үйлчилгээ үзүүлэхийн хувьд хандив, бэлэг хоёр төсөөтэй ажээ.

**14.Хуульд нийтийн албан тушаалтан бүтээлч ажил эрхэлж болохоор заасан байна. Бүтээлч ажил гэдэгт юуг хамааруулан ойлгож болох вэ?**

- Төлбөр, орлого олж байгаа сэтгүүл зүй, утга зохиолын болон урлагийн бүтээлийг бүтээлч ажил гэж ойлгоно. Нийтийн албан тушаалтан уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.2-т заасанчлан багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажлыг давхар эрхэлж болно. Гэхдээ 18 дугаар зүйлийн 18.3-18.4-т заасан албан тушаалтнууд буюу Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

**15.Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ямар арга хэмжээ авах үүрэгтэй вэ?**

- Хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т төрийн байгууллагын удирдлагын энэ чиглэлээр хүлээх үүргийг заасан байна. Төрийн байгууллагын удирдлага нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх, уг хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх үүрэгтэй. Хэрэв албан тушаалтны ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг, мөн түүнчлэн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг хянан шалгах явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

**16.Төрийн байгууллагын удирдлага энэ хуулиар хүлээсэн нийтлэг үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага тооцох вэ?**

- Албан тушаалтны ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг, мөн түүнчлэн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг хянан шалгах явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүргээ биелүүлээгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтныг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Тухайлбал, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**17.Хуульд тусгасан мэдэгдэл, мэдүүлэг нь ялгаатай ойлголт уу?**

- Ялгаатай. Нэршлийн хувьд ч нэг нь “мэдүүлэг”, нөгөө нь “мэдэгдэл”. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг тодорхой ажил, албан үүргээ гүйцэтгэхийн өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлж гаргана. Харин Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуульд заасан тодорхой хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

**18.Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг ямар тохиолдолд гаргах вэ?**

- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын

зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

**19.Мэдэгдэл гаргахаас гадна ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдал үүсвэл хэрхэх вэ?**

- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй” хэмээн заажээ. Түүнчлэн ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. Албан тушаалтан өөрөө ийнхүү мэдэгдэхээс гадна ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болохоор хуульд заасан.

**20.Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно. Гэтэл энэ үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Энэ тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

**21.Хэрэв албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилтэй байвал хэрхэн шийдвэрлэх вэ?**

- Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэхийг нэн даруй шийдвэрлэнэ. Шийдвэрийг тухайн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд бичгээр гаргасан тайлбар, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн бичгээр гаргах ёстой.

**22.Хэрэв ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг**

### **өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх талаар шийдвэр гаргаагүй бол яах вэ?**

- Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

### **23.Ашиг сонирхлын зөрчилтэй талаар мэдэгдсэн атал албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болох уу?**

- Ашиг сонирхлын зөрчилтэйгээ мэдэгдсэн албан тушаалтныг хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан хоёр тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно. Өөрөөр хэлбэл, 1) тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй; 2) мөн тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно.

### **24.Албан тушаалтан албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлын талаар ямар байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх вэ?**

- Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

### **25.Албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдуулан хэн нэгнээс бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болговол яах ёстой вэ?**

- Энэ тохиолдолд тухайн саналаас татгалзах, санал тавьсан этгээдийг тодорхойлох, тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг

хадгалах ба энэ тухай өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх, боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх, болсон нөхцөл байдлын талаарх мэдэгдлээ боломжит хугацааны дотор өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлэх, хариуцлага хүлээлгэхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх ёстой.

## **26. Энэ хуулиар албан тушаалтанд хэдэн төрлийн хориглолт, хязгаарлалтыг зохицуулсан бэ?**

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт албан тушаалтанд тавигдах нийт 12 төрлийн хориглолт, хязгаарлалтын талаар тусгасан. Үүнд:

- Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт;
- Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт;
- Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох;
- Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт;
- Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт;
- Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт;
- Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт;
- Хандив авахтай холбогдсон хязгаарлалт;
- Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт;
- Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт;
- Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт;
- Бусад орлогын хязгаарлалт.

## **27. Хориглолт ба хязгаарлалтын талаар хэлж өгнө үү?**

- Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглах, өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр

хөндлөнгөөс оролцохыг хуулиар хориглосон. Энэ зүйлд албаны мэдээллийг өөр ямар нэгэн байдлаар ашиглаж болох тухай заагаагүй тул бүрмөсөн хориглосон хэмээн ойлговол зохино. Харин албан тушаалтанд зарим үйлдлийг хориглож, тодорхой хэсгийг нь хэсэгчлэн хориглосон буюу хязгаарлахаар хуульчилжээ. Тухайлбал, хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу албан тушаалтан зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглосон боловч өөрийнхөө албан үүрэгт хамаарах сурталчилгаанд оролцож болохоор байна. Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөх, зарим тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө төлөөлөх, төлбөр, хандив, бэлэг авах, давхар ажил эрхлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах үйл ажиллагааг хуулиар хязгаарласан байна.

**28.Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийх удирдамж батлагдсаны дараа энэ талаар хамрагдах аж ахуйн нэгжид ажилладаг найздаа ярих нь хууль зөрчсөн үйлдэлд тооцогдох уу?**

- Тооцогдох үндэслэлтэй. Учир нь та нийтэд мэдээлэгдээгүй байгаа тухайн мэдээллийг бүрэн эрхийнхээ дагуу олж авсан бол ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүйн тулд хэнд ч энэ талаар ярих ёсгүй. Хяналт, шалгалтын ажлын удирдамжид хугацаа, хамрагдах аж ахуйн нэгж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн зэрэг мэдээллийг багтаасан байдаг бөгөөд тэр бүх мэдээллийг хууль бусаар задруулсан гэж үзнэ.

**29.Бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулсан, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашигласан албан тушаалтанд ямар хариуцлага тооцох вэ?**

- Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албан тушаалыг нь бууруулах бөгөөд дээрх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

**30.Албан тушаалтны эхнэр компьютер, тоног төхөөрөмж худалддаг бөгөөд тухайн байгууллагаас зарласан тендер шалгаруулалтад оролцож байгаа бол албан тушаалтан тендерийн үнэлгээний хороонд**

## **ажиллаж болох уу?**

- Болохгүй. Албан тушаалтны эхнэр нь түүнтэй хамаарал бүхий этгээд. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан.

### **31.Албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолтын талаар тодруулна уу?**

- Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу албан тушаалтанд албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

### **32.Албан тушаалтан өмнө нь ажиллаж байсан найзынхаа хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж болох уу?**

- Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” хэмээн заасан. Тиймээс албан тушаалтан тухайн байгууллагад ажиллахаа больсон өдрөөс хойш 2 жилийн дотор хамтран ажиллах гэрээ байгуулж болохгүй, өөрөөр хэлбэл, нийтийн албанд ажиллаад хоёр жилийн хугацаа өнгөрсөн бол болно. Гэхдээ энэ хориглолт нь тухайн албан тушаалтан нэгдмэл сонирхолтой байсан этгээдтэй албан үүргийн дагуу, нийтийн албыг төлөөлж гэрээ байгуулахад хамаарна. Жишээлбэл, өөрийн ажиллаж байгаа төрийн байгууллагад шаардлагатай бараа материал, эсхүл ямар нэг үйлчилгээ авахын тулд урьд хамтран ажиллаж байсан найзтайгаа гэрээ байгуулж болохгүй. Харин нийтийн албан тушаалтны хувиар бус хувийн зорилгоор, иргэн хүнийхээ

хувьд хамтран ажиллах гэрээ байгуулж болох талтай. Үүнд жишээлбэл, төрийн байгууллагын нэрийн өмнөөс биш, харин өөрийн хувийн хэрэгцээнд зориулан ямар нэгэн гэрээ байгуулж болох юм.

**33.Тэгвэл нэгдмэл сонирхолтой биш этгээдийн аж ахуйн нэгжид өмнө нь ажиллаж байгаад нийтийн албанд орсон бол тухайн аж ахуйн нэгжид хамаарах шийдвэрийг гаргаж болох уу?**

- Энд мөн л хоёр жилийн хугацаа заасан. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш 2 жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны акт гаргахыг хориглоно” гэж заасан. Тиймээс нэгдмэл сонирхолтой биш, эсхүл мөн эсэхээс үл хамааран нийтийн албанд орсон, эсхүл өмнө ажиллаж байсан аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш 2 жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжид хамаарах шийдвэрийг гаргаж болохгүй.

**34.Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Хуулийн 11 дүгээр зүйлд албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтын талаар зааж өгсөн. Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т зааснаар 11 дүгээр зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Жишээлбэл, албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтын нэг хэлбэр болох албан тушаалтан өөртэй нь хамаарал бүхий этгээд буюу өөрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр, нөхрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргасан нь түүнийг ажлаас халах үндэслэл болно.

**35.Төрийн албаны тухай хуульд заасан албан**



**тушаалтан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэхийг хориглосон заалт нь энэ хуулийн давхар ажил эрхлэлттэй холбогдох заалттай зөрчилдөж байгаа юу?**

- Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар уг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9 буюу аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэх, бусдад зуучлах тухай заалтыг хүчингүй болгосон.

**36.Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох гэж юуг хэлж байна вэ?**

- Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасан. Энэ заалтын дагуу албан тушаалтан бусад этгээдийг шийдвэр гаргахад нь хөндлөнгөөс нөлөөлөх нь хууль бус үйлдэл болно. Жишээлбэл, дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын согтуугаар машин барьж замын хөдөлгөөнд оролцсон асуудлыг шалгаж байгаа тухайн дүүргийн замын цагдаагийн байцаагч руу ярьж хөнгөн шийтгэл оноохыг шаардах нь өөрийн албан тушаалын байдлыг ашиглан нөлөөлж буй хууль бус үйлдэл болно.

**37.Дээрх заалтыг зөрчсөн албан тушаалтанд ямар хариуцлага тооцох вэ?**

- Мөн адил эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нийтийн албанаас халах сахилгын шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан хүлээлгэнэ.

**38.Жолооч нарт зориулсан замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж зорчих тухай сурталчилгаанд гаалийн байцаагч оролцож болох уу?**

- Болохгүй. Гаалийн байцаагч нь гаалийн мэдүүлэг үнэн зөв бөглөх гэх мэт өөрийнхөө албан үүрэгт хамаарах асуудлаарх зар сурталчилгаанд оролцож болох юм. Хуулийн

13 дугаар зүйлийн 13.1-д “Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно” гэж заасан. Харин иймэрхүү төрлийн сурталчилгаанд замын цагдаагийн албан хаагч нар гэх мэт зам тээвэр болон замын хөдөлгөөний дүрмийг сахиулахтай холбоотой албан үүрэг гүйцэтгэдэг нийтийн албан тушаалтан оролцож болно.

**39. Албан тушаалтан “Ус-чандмань эрдэнэ”, “Цахилгаанаа хэмнэе” гэх зэрэг нийгмийн шинж чанартай сурталчилгаанд оролцож болох уу?**

- Иймэрхүү төрлийн нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд бүх нийтийн албан тушаалтнууд оролцох эрхгүй. Нийгэмд тустай үйл ажиллагааны дээрх төрлийн сурталчилгаанд зөвхөн Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүд оролцох боломжтой. Бусад албан тушаалтан өөрийн албан үүрэгт хамаарахаас бусад төрлийн сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хуулиар хориглосон гэсэн үг юм.

**40. Хэрэв өөрийнхөө албан үүрэгт хамааралгүй зар сурталчилгаанд оролцсон бол энэ хуулийн дагуу ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнээс бусад албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцсон буюу хуулийн 13 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг зөрчсөн бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулна, хэрэв энэ зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах, цаашлаад нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэхээр заажээ.

**41. Хуульд албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө төлбөр авахыг хязгаарласан. Үүнийг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Албан тушаалтан Та албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авах, мөн хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авах ёсгүй.

Энэ харилцааг хуулийн 15 дугаар зүйлээр зохицуулсан бөгөөд энэ зүйлийг зөрчсөн бол нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэхээр хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т заасан болно.

#### **42. Албан тушаалтан бэлэг авч болох уу?**

- Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд болон шууд бусаар авахыг хориглоно. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалтыг хуульд нэг бүрчлэн тусгасан. Харин энэ хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй.

#### **43. Албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг гэж юуг ойлгох вэ?**

- Тухайн албан тушаалтны ажил, албан үүргийг үл тооцон өгсөн бэлгийг албан үүрэгтэй нь холбогдолгүй хэмээн авч үзэж болно. Албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг явуулсан үйл ажиллагаатайгаа холбоогүйгээр хүлээн авсан бэлгийг албан үүрэгтэй нь холбогдолгүй гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, тухайн албан тушаалтны төрсөн өдөр, насны ой болон баяр ёслол, тэмдэглэлт өдрийг тохиолдуулан гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, найз нөхөд, бусад этгээдээс авсан бэлгийг “албан үүрэгтэй нь холбогдолгүй” гэдэгт хамааруулан ойлгож болно.

#### **44. Албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг гэдэгт ямар бэлэг хамаарах вэ?**

- Хуульд албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, тайлагнах, зарцуулах журмыг Засгийн газар батлахаар заасан бөгөөд уг журмаас дипломат журмаар өгсөн бэлэгт ямар бэлэг хамаарахыг үзээрэй.

#### **45. Би багын найзынхаа ажиллуулдаг усан бассейнд хагас жилийн турш үнэгүй үйлчлүүлэх эрхийн бичгийг төрсөн өдрөөрөө бэлгэнд авсан. Энэ тохиолдолд би хэрхэх ёстой вэ?**

- Хэрэв тэрхүү эрхийн бичгийн үнийн дүн таны нэг сарын

цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн бол энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ёстой. Учир нь хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн бол дээрх хугацаанд мэдэгдэх үүрэгтэй. Түүнчлэн нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд мөн хугацаанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй ажээ.

**46.Хэрэв албан тушаалтан албан үүрэгтэйгээ холбогдолгүй бэлэг авсан бол тухайн бэлгийг өөртөө авч болох уу?**

- Албан тушаалтны албан үүрэгтэйгээ холбогдолгүй авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалингийн хэмжээнээс хэтрээгүй бол өөртөө үлдээнэ. Харин зургаан сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд бэлгийг төрийн өмчид шилжүүлнэ. Гэхдээ төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зургаан сараас илүү гарсан зөрүүг өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авч болно. Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг Засгийн газар баталсан бөгөөд энэ талын нарийвчилсан зохицуулалтыг уг журмаас үзэж болно. Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх шагналыг ч мөн энэхүү журмаар зохицуулна.

**47.Ямар тохиолдолд бэлгийг албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан авсан гэж үзэх вэ?**

- Хэрэв албан тушаалтан нь холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахдаа бэлэг авсан бол албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно. Албан тушаалтан бэлэг авахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.

#### **48.Бэлэг авсны дараах хязгаарлалт бий юу?**

- Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс бэлэг авсан бол албан тушаалтан тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүргийг хоёр жилийн хугацаанд гүйцэтгэхгүй.

#### **49.Бэлэгтэй холбоотой өөр хориглолт бий юу?**

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.

#### **50.Бэлэг авахтай холбогдсон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т заасны дагуу шүүгч албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэх ба мөн зүйлийн 29.2.4-т заасны дагуу нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй гэдгийг анхаараарай.

#### **51.Хандив авахтай холбогдсон харилцааг хуулиар хэрхэн зохицуулсан бэ?**

- Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” хэмээн заасан.

#### **52.Авч болох хандив гэж бий юу?**

- Бий. Хамгийн чухал нь албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээд тухайн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив байх ёстой. Албан тушаалтан нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг хандив, бусад санхүүгийн туслалцааг авч болно. Гэхдээ хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх ёстой. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагад энэ заалт мөн адил хамаарна.

### **53.Хандив, санхүүгийн туслалцааг авсны дараах хориглолт гэж бий юу?**

- Бий. Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

### **54.Албан тушаалтан аавынхаа захирлаар нь ажилладаг төрөлх сургуулийнхаа ойг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнд ажиллаж, улмаар ойг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор хандив цуглуулахад оролцож болох уу?**

- Болохгүй. Албан тушаалтан хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд биечлэн болон бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглодог. Учир нь албан тушаалтны аав нь түүнтэй хамаарал бүхий этгээд. Жишээлбэл, Дорж төрийн захиргааны албан хаагч. Түүний хадам ах нь хүнд өвчний улмаас Солонгос улсад эмчлүүлэхээр болсон түүнд зориулж хандив цуглуулах ажлыг хадам эцэг нь Доржоор удирдуулжээ. Энэ тохиолдолд Дорж хууль зөрчөөгүй байна. Хуульд албан тушаалтан хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатай бол хандив хүсэх, цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоогүй. Үүнээс гадна албан тушаалтан өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд, мөн өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд зориулан биечлэн, эсхүл бусад этгээдээр

зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно.

**55.Хандив авахтай холбогдсон хуулийн хязгаарлалтыг зөрчсөн албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Хэрэв хандив авахтай холбогдсон хязгаарлалтыг зөрчсөн бол эрх бүхий албан тушаалтан хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т заасанчлан албан тушаалыг нь бууруулах бөгөөд энэ зөрчлийг удаа дараа гаргавал нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Жишээлбэл, Саран нэгэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар ажилладаг. Дүүргийнхээ 50 жилийн ойг угтаж нутаг дэвсгэртээ байрлаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив цуглуулах ажлыг зохион байгуулж, цугларсан 15 сая төгрөгийг хандивын дансанд тушаажээ. Энэ тохиолдолд хуулийн хандив авахтай холбогдох заалтыг зөрчсөн тул Саранд дээр дурдсан сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

**56.Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрсөн өөр ямар ажил, албан тушаал эрхэлж болох вэ?**

- Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтнаас бусад албан тушаалтан хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил, багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил, ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг гүйцэтгэж болно. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан нь салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно. Харин зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно.

**57.Би сүүний чиглэлийн хэдэн үнээтэй. Би албан ажлынхаа хажуугаар энэ аж ахуйгаа эрхэлдэг. Хуулиар үүнийг хориглох уу?**

- Хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д “Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь 10 сая төгрөгөөс хэтрэхгүй, эсхүл зөвхөн өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, аялал, бусад сургалтын үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно” гэж заасан. Жишээлбэл, Дорж Төв аймгийн нэгэн суманд хэсгийн төлөөлөгчөөр ажилладаг. Тэрээр сумандаа хүнсний ногооны тариалан эрхэлж, жилдээ 3 сая төгрөгийн орлого олдог. Доржийн давхар ажил эрхлэхийг хуулиар хориглохгүй.

### **58.Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлаас томилогдсон хяналт, шалгалтын ажлын хэсэгт ажиллаж болох уу?**

- Болно. Зөвхөн Засгийн газрын гишүүн /сайд/ Улсын Их Хурлаас томилогдсон хяналт, шалгалтын ажлын хэсэгт орж ажиллаж болно. Харин Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг, түүнчлэн хяналт, шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно” гэж хуулийн 18 дугаар зүйлийн 18.7-д заасан байна. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Чүлтэм нь Улсын Их Хурлаас байгуулагдсан хөдөлмөр эрхлэлтийн сангийн хөрөнгийн гүйцэтгэлийг шалгах ажлын хэсэгт орж ажиллажээ. Энэ тохиолдолд тэрээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллахыг хориглосон хуулийн заалтыг зөрчжээ.

### **59.Давхар ажил эрхлэлт нь ямар үр дагавартай байдаг вэ?**

- Төрийн албанд ажилладаг хүн үндсэн ажлаас гадуур ажил эрхлэх нь авлигад өртөх нэг шалтгаан болдог. Төрийн албан хаагч өөр ямар нэгэн төрийн ба бусад байгууллагад цалин хөлс авч ажиллахыг байгууллагаас гадуурх ажил эрхлэлт гэж үзнэ хэмээн “Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага”-д тодорхойлжээ. Хувийн бизнес эрхлэх, төлбөртэй зөвлөгөө өгөх, компани буюу байгууллагын удирдах, захиргааны зөвлөлд байхыг үүнд хамааруулдаг байна. Төрийн байгууллагын албан хаагч үндсэн ажлаас гадуур ажил



эрхэлснээр ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн өмч ба мэдээллийг зохисгүй ашиглах, байгууллагын зохион байгуулалт, ажлын гүйцэтгэл, ажилтнуудын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажээ. Гэхдээ давхар ажил эрхлэлтийг ямагт сөргөөр харж, хэт хатуу хандвал хүний нөөц бүрдүүлэх, тогтвор суурьшлыг хангахад сөргөөр нөлөөлж болзошгүй хэрэгцээ шаардлагад үндэслэн давхар ажил эрхлэх хязгаарлалт, хориглолтыг хуульчилж өгсөн болно.

### **60. Нийтийн албанд шинээр орж байгаа хүн давхар эрхэлж байгаа ажил, үүргээ хэрхэн танилцуулах вэ?**

- Энэ тухай эрх бүхий дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулна. Хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа тохиолдолд заавал танилцуулах шаардлагатай. Уг танилцуулгыг хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ. Жишээлбэл, хувиараа эм ханган нийлүүлэх байгууллага ажиллуулж байсан Солонго нэгэн дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэст ажилд оржээ. Солонго шинэ ажилд орох үед шинэ ажлынхаа удирдах албан тушаалтанд эрхэлж байсан албан ажлынхаа талаар бичгээр мэдэгдсэн байна. Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга нь энэ танилцуулгыг хүлээн авч 15 хоногийн дараа жилд 20 саяас дээш орлого олдог өмнө эрхэлж байсан ажлаасаа чөлөөлөгдөх шаардлагатайг мэдэгдсэн байна.

### **61. Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй. Гэтэл энэ үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Тухайлбал, албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, энэ зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах, нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэхээр хуулийн 29 дүгээр зүйлд заасан байна. Жишээлбэл, аялал жуулчлалын чиглэлээр бизнес эрхэлж

байсан Марал жилд 18 сая төгрөгийн орлоготой ажилладаг байжээ. Тэрээр Аялал жуулчлалын яаманд мэргэжилтнээр ажилд орсон байна. Нийтийн албанд орохдоо дээд шатны албан тушаалтанд өөр ажил эрхэлж байгаа тухайгаа мэдэгдээгүй тул түүнд албан тушаалын цалинг нэг сар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

**62.Тэгвэл хуулиар зөвшөөрөөгүй ажил гүйцэтгэж байгаагаа бичгээр танилцуулсан байхад уг танилцуулгыг хүлээн авсан албан тушаалтан хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Энэ үүргээ биелүүлээгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтныг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Жишээлбэл, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэст шинээр ажилд орсон албан хаагч жилийн 25 сая төгрөгийн орлоготой ажилладаг давхар ажил эрхэлж байсан тухайгаа бичгээр танилцуулсан байна. Үүнээс хойш хагас сарын хугацаа өнгөрсөн боловч танилцуулгыг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан асуудлыг шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй тул шүүгч түүнд торгох захиргааны хариуцлага хүлээлгэжээ.

**63.Албан тушаалтан аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхэлж болох уу?**

- Хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д “Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь 10 сая төгрөгөөс хэтрэхгүй, эсхүл зөвхөн өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, аялал, бусад сургалтын үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно” гэж заасан. Албан тушаалтан эдгээрээс бусад буюу хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.

**64.Албан тушаалтанд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон өөр ямар хязгаарлалт байдаг вэ?**

- Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх

хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.

**65.Өмнө дурдсан хориглосон үйлдлийг гаргасан бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т зааснаар тухайн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох захиргааны хариуцлагыг шүүгч хүлээлгэнэ.

**66.Тендерийн хорооны гишүүн тендерт оролцсон аж ахуйн нэгжээс тодорхой хувь, ашиг хүртдэгийг энэ хуулиар хориглосон уу?**

- Хориглосон. “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно” гэж хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заажээ.

**67.Хэрэв ашиг хүртсэн бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Энэ тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3, 29.2.4-т заасанчлан албан тушаалыг нь бууруулах, дээрх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас хална.

**68.Албан тушаалтанд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа ямар хязгаарлалт тавьдаг вэ?**

- Нийтийн албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах, урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрөл хүсэх, урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх үед ашиг

сонирхлын зөрчил үүсч болох үйл ажиллагааг явуулахыг хориглоно.

**69. Дээрх хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Дээрх хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох захиргааны хариуцлага хүлээлгэхээр хуульд заасан байна.

**70. Албан үүргээсээ чөлөөлөгдсөн этгээдтэй албан тушаалтан нь албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоож болох уу?**

- Албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглосон. Хэрэв энэ заалтыг зөрчсөн бол албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаанд 30 хувиар бууруулах, зөрчлийг удаа дараа гаргавал албан тушаал бууруулах, нийтийн албанаас халах арга хэмжээ авна.

**71. Албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох үйл ажиллагаа явуулахгүй байх хязгаарлалтыг зөрчиж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүргээ биелүүлээгүй этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Энэ нь албан тушаалтны үүрэг бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Зөрчлийг удаа дараа гаргавал албан тушаал бууруулах, нийтийн албанаас халах арга хэмжээ авна.

**72. Би нийтийн албанаас чөлөөлөгдөж, хувийн компанид ажиллах болсон. Манай компани миний өмнө ажиллаж байсан байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байдаг юм байна. Гэхдээ намайг одоогийн ажилдаа орохоос өмнө энэ гэрээг байгуулжээ. Тэгэхээр энэ нь надад хамаатай хориглолт, хязгаарлалт болох уу?**

- Танд хамаарахгүй. Яагаад гэвэл хуульд урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрөл хүсэх үйл ажиллагаа явуулах хориглолт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилд долоон сая төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, контрактад хамаарахгүй байхаар заажээ.

**73. Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа бол давхар цалин авах уу?**

- Үгүй. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т зааснаар зөвхөн Засгийн газрын гишүүний цалин авна.

**74. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байсан албан тушаалтанд ямар үйл ажиллагааг хориглох вэ?**

- Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах; холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах; холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах; холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэхийг хориглоно.

**75. Өмнө дурдсан заалтыг зөрчсөн этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Тухайн хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдээр хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар орсон албан тушаалаас чөлөөлөх хариуцлага хүлээлгэх ажээ.

**76.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэн гаргах вэ?**

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээд болон тэдгээр албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргана. Шаардлагатай тохиолдолд УИХ-ын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг гаргах бөгөөд энэхүү жагсаалтад багтсан албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлоо мэдүүлнэ. Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй.

**77.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хэзээ гаргаж өгөх ёстой вэ?**

- Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргана. Мэдүүлгээ уг хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэй.

**78.Хэрэв заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ гаргаагүй бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т заасны дагуу албан тушаалтныг нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

**79.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан хугацаанаас хожимдуулж гаргасан бол ямар хариуцлага хүлээх вэ?**

- Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан хугацаанаас хожимдуулж гаргасан бол уг мэдүүлгийг гаргаж өгөөгүйд тооцно. Энэ тохиолдолд албан тушаалтныг нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

**80.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хожимдуулж гаргасан бол яах вэ?**

- Мэдүүлгээ заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах арга хэмжээ авна. Хэрэв удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, энэ зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах, цаашлаад нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

**81.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн албан тушаалтанд ямар хариуцлага хүлээх вэ?**

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн бол албан тушаалтны албан тушаалыг нь бууруулах, энэ зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээнэ.

**82.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хэн хүлээж авах вэ?**

- Тухайн албан тушаалд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. Авлигатай тэмцэх газар урьдчилсан мэдүүлгийг ажлын 10 өдөрт багтаан хянан үзээд тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

**83.Хэрэв ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдвол яах ёстой вэ?**

- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол түүнийг тухайн албанд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан томилохоос татгалзах үүрэгтэй.

**84.Нэр дэвшсэн этгээдийг тухайн албан тушаалд томилох эрх бүхий албан тушаалтан хууль зөрчиж, илт ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд**

## **томилсон бол хүлээлгэх хариуцлага бий юу?**

- Бий. Энэ тохиолдолд буруутай этгээдийн албан тушаалыг бууруулах бөгөөд удаа дараа зөрчил гаргавал нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

## **85.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг ямар байгууллагууд бүртгэж, хадгалах вэ?**

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, дээрхээс бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан бүртгэж, хадгална.

## **86.Ямар байгууллага, албан тушаалтан ямар хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг Авлигатай тэмцэх газарт ирүүлэх вэ?**

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтан, Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчээс бусад нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан жил бүрийн 2 дугаар сарын 15-наас хойш 14 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайлан, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх



газарт ирүүлэх ёстой.

**87. Авлигатай тэмцэх газарт тайлан, нэрсээ ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох баримт бичгийг заасан хугацаанд буюу 14 хоногийн дотор ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтныг шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

**88. Авлигатай тэмцэх газар хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг хэзээ, хаана гаргах вэ?**

- Жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө.

**89. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй танилцах боломж бий юу?**

- Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй бөгөөд Авлигатай тэмцэх газар, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо; Шүүхийн ерөнхий зөвлөл, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, бусад албан тушаалтныг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

**90. Хэрэв албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй эрх бүхий байгууллага танилцах боломж олгоогүй бол яах вэ?**

- Энэ тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

**91. Албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын**

**мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт нь иргэдэд нээлттэй байх уу?**

- Захидал, хүсэлт, асуулт болон тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна.

**92.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэн хянан шалгах вэ?**

- Авлигатай тэмцэх газар өөрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгээс бусад хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ. Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно. Улсын Их Хурлын гишүүнээс бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл бүрэн гүйцэд гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шалгана.

**93.Тэгвэл Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэн шалгах вэ?**

- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо шалгана.

**94.Харин Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэн шалгах вэ?**

- Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо шалгана.

**95.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан түүнийг хянан шалгах талаар ямар үүрэг хүлээсэн бэ?**

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт

тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу авлигын шинжтэй зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

**96. Дээрх үүргээ биелүүлээгүй тохиолдолд албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх вэ?**

- Хуулиар хүлээсэн дээр дурдсан үүргээ биелүүлээгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

**97. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах үүрэг хүлээдэг үү?**

- Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй.

**98. Энэ хуулийн хэрэгжилтэд ямар байдлаар хяналт тавих вэ?**

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Авлигатай тэмцэх газар хяналт тавина. Өөрөөр хэлбэл, хуулийг хэрхэн дагаж мөрдөж байгаад Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо нь Авлигатай тэмцэх газар ба Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавина. Харин Авлигатай тэмцэх газар нь бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

**99. Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болох уу?**

- Болохгүй.

**100. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг**

**сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэсэн сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг олон нийт хаанаас олж мэдэж болох вэ?**

- Дээрх хууль тогтоомжийг зөрчсөн албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүргийг хүлээсэн бөгөөд мэдээллийг хэрхэн хүргэх харилцааг хуульд заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын баталсан журмаар зохицуулсан байна.

